



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 102

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад хэлтсийн даргын 2017 оны 12 сарын 20-ны өдрийн Б/64 тоот тушаалаар сахилгын шийтгэлтэй 7 ажилтанд 1660,5 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Зориулалт бусаар олгосон 1,660,500 / Нэг сая зургаан зуун жаран мянга таван зуун/ төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2518085

Хоёр. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат, нягтлан бодогч У.Өлзийбаяр нарт хариуцуулав.

АКТЫГ



ТОГТООСОН¹:

АУДИТОР *П. Мөнх-Эрдэнэ* П.МӨНХ-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д. Мөнхбат* Д.МӨНХБАТ

НЯГТЛАН БОДОГЧ *У. Өлзийбаяр* У.ӨЛЗИЙБАЯР



D:\Munkherdene_2018\Akt_2018\TA_Emndheltes.Docx

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 83

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад сумын ЗДТГ-ын автомашины сэлбэг, засварын зардалд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.1 дэхь "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зориулалт бусаар зарцуулсан 2556,0 /Хоёр сая таван зуун тавин зургаан мянга/ төгрөгийг сумын ЗДТГ-аар төлүүлж, Галуут сумын Төрийн сан дахь Орон нутгийн хөгжлийн сангийн 100030152400 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 06 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт

2518047


ирүүлэхийг Галуут сумын Засаг дарга С.Баярсайхан, Санхүүгийн албаны дарга Ж.Баярсайхан нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН ¹:
АУДИТОР *П. Мөнх-Эрдэнэ* П.МӨНХ-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С. Баярсайхан
С БАЯРСАЙХАН
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА
Ж. Баярсайхан
Ж БАЯРСАЙХАН



D:\Munkherdene_2018\Akt_2018\TA_Galuut_ONHS.Docx

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 17

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. Томилолтын зардлыг 22,5 мянган төгрөгөөр ажилтанд илүү олгосон.

Энэ нь "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 2-т "Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь ... төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгох..." заалтыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" зөрчилд төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон 22,5 /Хорин хоёр мянга таван зуу/ төгрөгийг жолооч Х.Зориггоогоор төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2517061

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 03 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Т.Норов, нягтлан бодогч С.Гэрэлмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

 <p>ТОГТООСОН ¹:</p> <p>АУДИТОР <i>П.Мөнх-Эрдэнэ</i> П.МӨНХ-ЭРДЭНЭ</p> <p>6417143544 БҮОА0067 9007423</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА <i>Т.Норов</i> Т.НОРОВ</p> <p>НЯГТЛАН БОДОГЧ <i>С.Гэрэлмаа</i> С.ГЭРЭЛМАА</p>
---	--

D:\Munkherdene_2018\Akt_2018\TA_Ghbhbgazar.Docx

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 83

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад сахилгын шийтгэлтэй 6 ажилтанд 1620.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэлийг зөрчсөн байна.




Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:



1. Зориулалт бусаар олгосон 1620.0 /Нэг сая зургаан зуун хорин мянга/ төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2518049

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 5 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурванбулаг сумын ЗДТГ-ын дарга Р.Гантулга, нягтлан бодогч Б.Дэлгэрдалай нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН ¹ :	ЗӨВШӨӨРСӨН:
АУДИТОР  П.МӨНХ-ЭРДЭНЭ	ЗДТГ-ЫН ДАРГА  Р.ГАНТУЛГА
	НЯГТЛАН БОДОГЧ  Б.ДЭЛГЭРДАЛАЙ



D:\Munkherdene_2018\Akt_2018\TA_Gurvanbulag_ZDTG.Docx

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.